



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 411

Чингис хот

Аялал жуулчлалын дэд зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Аялал жуулчлалын үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах, сурталчлах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, жижиг дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэх замаар нутгийн иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах, аялал жуулчлалын салбарын үйлчилгээний байгууллагуудын чанар, стандартыг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг судлах, санал зөвлөмж өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, холбогдох агентлаг, байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангаж ажиллах үүрэг бүхий аймгийн аялал жуулчлалын дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд зөвлөлийн
дарга

Г.Хэрлэнчулуун

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд

Э.Мөнх-Эрдэнэ

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Б.Дархантөр

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
дарга

Ч.Пүрэвдорж

Стандарт хэмжилзүйн хэлтсийн дарга

С.Амгаланбаатар

Мэргэжлийн хяналтын газрын Байгаль
орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын
хэлтсийн дарга, Улсын хяналтын ахлах
байцаагч

Х.Эрдэнэчимэг

Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний
чанар, стандартын хяналтын улсын
байцаагч

С.Баатарсүх

Хэрлэн голын сав газрын захиргааны
Гадаргын усны нөөц, чанарын асуудал
хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Бат-Эрдэнэ

Онцгой байдлын газрын Гамшгаас
хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч


231010035

Нарийн бичгийн дарга	Б.Баясгалан	2. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн
	Ч.Нарантуяа	"Ханбүргэд" ХХК-ны захирал /зөвшилцсөнөөр/
	Б.Мөнхжаргал	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн

2. Аялал жуулчлалын дэд зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т даалгасугай.

3. Аялал жуулчлалын үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах, аялал жуулчлалаас орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудалд төлөвлөгөө, удирдамж гарган хэрэгжүүлэх, Засаг дарга болон зөвлөлийн гишүүдийг мэдээлэл, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг дэд зөвлөлийн дарга /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА